


ХИЧЭЭЛ 6

УНШИХ ЗҮЙЛ: ҮЙЛС 9:1-22; ДАГАЛДАГЧДЫН ҮЙЛС, Х. 112-125.

Сохор Хүн Удирдаж Сурав

Та нар хэзээ нэгэн цагт явах зам чинь саадтай учраас өөр замаар явж үзсэн үү? Тийм бол тойруу замаар явах хэрэгтэй болно. Бурхан нэгэн удаа Саулыг тойруу замаар явуулжээ.

Саул Дамаск хотын тоостой замаар том том алхан явна. Цөлийн халуун нар дээрээс нь төөнөж түүнийг халууцуулна. Гэтэл түүний дотор бас уур хилэн буцалж байв. Үзэн ядалтандаа тэр бараг шатаж байсан юм. Цуг явсан хүмүүс нь түүнтэй зэрэгцэх гэж бараг гүйж явлаа. Саул Христэд итгэгчдийг үзэн яддаг байв. Дамаск хотоос аль болох олон Христэд итгэгчдийг барьж авна гэж тэрээр төлөвлөжээ.



Цээжлэх Ишлэл:
"Их Эзэн чамайг дахин хараатай болог гэж намайг илгээлээ"
үйлс 9:17.

Тол Санаа:
Бурхан биднийг бусдад туслуулахаар удирддаг.

Гэнэт Саулын эргэн тойронд асар хурц гэрэл бий боллоо.

Саул болон түүнийг дагаж явсан хүмүүс бүгд газар хөсөр унав. Тэр юу ч харж чадахаа больжээ. Хурц гэрэл нүдийг нь сохолсон байна. Дараа нь нэгэн хоолой сонсогдлоо.

"Саул, Саул, Чи юунд намайг хавчина вэ?"

"Их Эзэн минь, та хэн бэ?" хэмээн Саул шивнэн асуув.

"Би бол чиний хавчин зовоож байгаа Есүс байна" гэж Есүс хариу хэлжээ. "Босоод хот руу оч. Тэнд байхад чинь хэн нэгэн

хүн уулзаж юу хийхийг чинь хэлж өгнө."

Саулыг дагаж явсан хүмүүс ч бас энэ дуу хоолойг сонсжээ. Гэхдээ юу гэж хэлснийг нь тэд ойлгосонгүй. Юу болоод байнаа гэж тэд гайхжээ. Саул босож зогсов. Эргэн тойрныг тойруулж харах гэсэн боловч тэр юу ч харж чадсангүй. Тэр сохорчээ. Эцэст нь хамт явсан хүмүүс нь түүнийг хот руу авч явсан байна.

Ананиа бол Дамаск хотод амьдардаг Бурханы хүмүүсийн нэг. Их Эзэн түүнийг "Ананиа" хэмээн дуудлаа.

"Их Эзэн минь, би энд байна" гэж Ананиа хариулав.


"Шулуун гэдэг гудамжаар яв. Тэгээд Иудасын гэрийг хайж ол. Дараа нь тэнд байгаа Саул гэдэг хүнийг олж уулз. Тэр одоо тэнд залбирч байгаа. Ананиа гэдэг хүн ирнэ гэж би Саулд хэлсэн. Түүний дээр гараа тавьж залбир. Тэгвэл тэр дахин хараатай болох болно."

Ананиа айж байлаа. "Гэхдээ Их Эзэн минь, Саул Христэд итгэгчдийн эсрэг муу зүйл хийдэг гэж олон хүн надад хэлсэн шүү дээ" гэж тэрээр эсэргүүцэв.

"Явж оч. Би түүгээр нэгэн онцгой ажил хийлгэх болно. Би түүнийг өөрийнхөө элчээр сонгосон."

Ананиа түүнийг дуулгавартай дагалаа. Тэрээр шулуун гудамжийг уруудан алхаж, Саулыг олж уулзлаа. "Саул ах минь," гэж Ананиа хэлээд "Их Эзэн Есүс намайг явууллаа. Чамайг дахин хараатай болгохын тулд бас Ариун Сүнстэй болгохын тулд намайг илгээсэн юм" гэж ярилаа. Ананиа гараа түүний дээр тавиад "Саул, Саул, чи одоо юм харж байна уу?"

Одоо Саул бүрмөсөн өөрчлөгджээ. Өмнө нь Христэд итгэгчдийг үзэн яддаг байсан хүн одоо тэдний нэг болов. Зүрх сэтгэлийг нь Есүс өөрчилсөнд Саул маш их баяртай байлаа. Одоо тэр үлдсэн амьдралаа бусдад Есүсийн тухай тунхаглах үйлсэд зориулах болно.



Дасгал Ажил

ШАББАТ

Энэ долоо хоногийн өдөр бүр үзсэн түүхээ хамтдаа уншаад цээжлэх ишлэлээ хөдөлгөөнтэй нь хийгээрэй.

- Их Эзэн**.....Дээш заах.
- чамайг**Хэн нэгэн рүү заах.
- дахин хараатай**Нүдээ заах.
- болог гэж намайг**.....Өөр рүүгээ заах.
- илгээлээ.**
- Үйлс 9:17**.....Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

НЯМ

Үйлс 9:1-22-г хамтдаа уншаарай. Асуух: Хэрвээ чи Дамаск руу явж байсан Саулын оронд байсан бол юу хийх байсан бэ? Та газар ямар нэг зүйл унагаад түүнийгээ хүүхдээрээ нүдийг нь аниулж байгаад олуулаарай.

ДАВАА

Шаббат хичээл дээр хийсэн Англи Брайл цагаан толгойгоор бичсэн Есүс гэдэг үгээ хэн нэгэнтэй хуваалцахад нь хүүхдээ урамшуулаарай. Мөн тэр хүнд Бурхан Саулд туслуулахаар Аниаг хэрхэн илгээсэн тухай яриулна уу.

Jesus



МЯТМАР

Хүүхдэдээ ус дүүргэсэн тунгалаг сав үзүүлээрэй. Хэлэх: Энэ сав бол Саултай адилхан. Тэрээр өдөр болгон Есүст итгэдэг хүмүүсийг ангуучилдаг байжээ. (Дараа нь усан дотор хүүхдээрээ будаг хийлгэнэ үү.) Өдөр ирэх тусам л тэр улам л муу зүйл хийнэ. (Өөр өнгө нэмж хийлгээрэй.) Харин Есүсийг түүнтэй ярихад Саул өөрийгөө өөрчлөгдөх хэрэгтэй гэдгийг

ойлгожээ. Есүс Саулын амьдралыг өөрчлөхөд тэр олон хүмүүст туслав. (Усан дахь өнгийг арилгахын тулд цайруулагч хийгээрэй.)

ЛХАГВА

Бурхан хэн нэгэнд туслуулахаар таныг дагуулсан тухай нэгэн түүхийг хүүхдэдээ ярьж өгөөрэй. Хүүхдээрээ туслуулж болох газар руу түүнийг дагуулж очоорой. (хөршийн чинь хашаа, утас эсвэл галын өрөө г.м хүүхэд тань тусалж болох бүх газар)

Гэр бүлд чинь танд тус болж чадах хичнээн гар хөл байгааг тоолоорой.



ПҮРЭВ

Хүүхдэдээ хуруугүй гал зуухны бээлий өмсгөөд үзэм түүлгэх гэж оролдуулаарай. Асуух: Хэцүү байсан уу, амархан байсан уу? Хэрэв хуруу чинь сайн хөдөлдөггүй байсан бол яах вэ? Саул юм харахаа болжээ. Гэвч Бурхан түүнд зориулан тусгай төлөвлөгөө бэлдсэн байжээ. Энэ юу байсан бэ? Та хэрхэн өөрчлөгдсөн тухайгаа хүүхдэдээ ярьж өгөөрэй. Бурхан чамайг удирдаж байна гэдгийг чи хэзээ мэдсэн бэ?

БААСАН

Библийн түүхийг гэрийнхэнтэйгээ хамт жүжиглээрэй. Хурц гэрлийг гар чийдэнгээр гаргаарай. Залбирахаасаа өмнө амлалтын тухай дууг дуулаарай. Маргааш Нийтэд тустай төсөлд зориулан авч явах зүйлсийг нь цуглуулаарай.